

ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2014 оны 4-р сарын 30-ны байдлаар*


2014 оны 4-р сарын 30-ны байдлаар хүнсний гол нэрийн барааны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 5.4 хувь, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 1.6 хувиар өссөн байв.

Махны дундаж үнэ: 2014 оны 4-р сарын 30-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сарынхаас 11.7 хувь, үхрийн цул мах 7.0 хувь, адууны мах 3.8 хувь, үхрийн ястай мах 2.2 хувь, ямааны мах 1.0 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногийнхоос үхрийн ястай махны үнэ 4.6 хувь, хонины ястай мах 4.0 хувь, ямааны мах 3.9 хувь, адууны мах 3.7 хувь, үхрийн цул махны үнэ 1.6 хувиар өссөн байна.

2014 оны 4-р сарын 30-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7865 төгрөг, үхрийн /ястай/ мах 8610 төгрөг, үхрийн цул мах 10670 төгрөг, адууны мах 6795 төгрөг, ямааны мах 5780 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).


Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ



Гурилын үнэ: 2014 оны 4-р сарын 30-ны байдлаар дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ өмнөх сарынхаас 3.9 хувь, өмнөх 7 хоногийнхоос 2.4 хувиар буурч, дээд зэргийн савласан гурил өмнөх сарынхаас өөрчлөлтгүй, өмнөх 7 хоногийнхоос 0.4 хувиар өссөн байна. 1-р зэргийн гурилын үнэ өмнөх сарынхаас 11.7 хувь, өмнөх 7 хоногийнхоос 4.2 хувиар өсч, 2-р зэргийн гурилын үнэ өмнөх сарынхаас 5.0 хувь, өмнөх 7 хоногийнхоос 2.5 хувиар өссөн байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2014 оны 4-р сарын 30-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос 0.2 хувиар буурсан бол элсэн чихэр өмнөх сарынхаас 0.3 хувиар өсч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна. (Зураг 2).

Зураг 2



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2014 оны 4-р сарын 30-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад сонгиноны үнэ 0.4 хувь, луувангийн үнэ 3.7 хувиар буурч, төмсний үнэ 0.5 хувь, байцааны үнэ 3.9 хувь, манжингийн үнэ 2.5 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногийнхоос төмсний үнэ өөрчлөлтгүй, байцаа, лууван, сонгиноны үнэ 0.4 хувь, манжингийн үнэ 0.3 хувиар буурсан байна.

Сүү, өндөг, ургамлын болон цэцгийн тосны дундаж үнэ: 2014 оны 4-р сарын 30-ны байдлаар өмнөх сарынхаас савласан /1 литрийн/ сүүний үнэ 9.4 хувь, “Элекстер” /0.5 л/ савласан сүүний үнэ 26.6 хувиар өсч, задгай сүүний үнэ 2.3 хувиар буурсан, өмнөх 7 хоногийнхоос “Элекстер” /0.5 л/ савласан сүү 0.4 хувиар өсч, савласан /1 литрийн/ сүүний, задгай сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос 0.6 хувиар буурч, өндөгний үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос 1.2 хувиар буурч, харин цэцгийн тосны үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

Хүнсний гол нэрийн барааны үнэ, аймгаар

Хүнсний гол нэрийн барааны 7 хоногийн үнийн судалгаанд аймгийн төвүүдээс гурил, мах, цагаан будаа, малын сүү, элсэн чихрийн үнийг судалдаг (Хавсралт хүснэгт 3).

Гурилын үнэ: 2014 оны 4-р сарын 30-ны байдлаар аймгийн төвүүдийн хүнсний зах, дэлгүүрт хэрэглээ ихтэй 1-р зэргийн гурилын үнэ 680-1100 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна. Гурилын үнэ өмнөх 7 хоногийнхоос Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ аймагт 20-100 төгрөгөөр өссөн байна.

Дорнод аймагт 1-р зэргийн гурилын үнэ хямд буюу 680 төгрөг байхад, Завхан аймагт 1100 төгрөг байгаа нь өндөр үнэ байна.

Махны үнэ: 2014 оны 4-р сарын 30-ны байдлаар хонины махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Архангай, Булган, Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий аймагт 100-500 төгрөгөөр өсч, Баян-Өлгий, Завхан, Увс, Дархан-Уул, Сүхбаатар аймагт 100-500 төгрөгөөр буурсан байна.

Хонины махны үнэ Архангай аймагт 8500 төгрөг байгаа нь өндөр бөгөөд Говьсүмбэр аймагт 6000 төгрөг байгаа нь хамгийн хямд үнэ байв.

Үхрийн махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Ховд, Өвөрхангай, Сэлэнгэ аймагт 500-900 төгрөгөөр өсч, Баян-Өлгий, Завхан, Дорноговь аймагт 250-500 төгрөгөөр буурсан байна. Үхрийн махны үнэ Төв аймагт 10000 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ бөгөөд Баян-Өлгий аймагт 5500 төгрөгөөр худалдаалагдсан нь хямд үнэ байв.

Ямааны махны үнэ Завхан, Баянхонгор, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Хэнтий аймагт 200-1000 төгрөгөөр өсч, Баян-Өлгий, Ховд, Архангай, Дархан-Уул, Сүхбаатар аймагт 200-500 төгрөгөөр буурсан байна. Ямааны мах Баян-Өлгий аймагт хямд буюу 5250 төгрөг байхад Өмнөговь аймагт 7800 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ байна.

Малын сүүний үнэ: 2014 оны 4-р сарын 30-ны байдлаар малын сүү аймагт 1100-2500 төгрөгийн үнэтэй худалдаалагдсан байна. Сүүний үнэ Орхон, Дархан-Уул, Дорнод аймагт 100-200 төгрөгөөр буурсан байна. Өмнөговь аймагт хамгийн /2500 төг/ өндөр үнэтэй байна.

Цагаан будаа, элсэн чихрийн үнэ: 2014 оны 4-р сарын 30-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх 7 хоногийнхоос Өмнөговь аймагт 70 төгрөгөөр өссөн байна. Нийт аймагт цагаан будаа 1 кг нь 2000-2400 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх 7 хоногийнхоос Увс аймагт 100 төгрөгөөр өсч, Өвөрхангай аймагт 100 төгрөгөөр буурсан байна. Элсэн чихэр 1 кг нь 1530-2000 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.